

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд 6.2.9 дэх заалт нэмсүгэй:

“6.2.9.шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны чиглэлээр Шүүхийн бус журмаар өр багадуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн бус журмаар өр багадуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг,” гэсний дараа “11.34 дүгээр зүйлийн 1.1-1.3 дахь заалт,” гэж мөн зүйлийн 6.18 дахь заалтын “11.33,” гэсний дараа “11.34 дүгээр зүйлийн 1.4,1.5 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн бус журмаар өр багадуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

**“11.34.Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг
зохицуулах тухай хууль зөрчих**

1.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгч нь:

1.1.өр төлбөртэй этгээд болон түүний төлөөлөгч, гуравдагч этгээдийн нэр хүндэд халдсан;

1.2.зээлдүүлэгчээс хүлээн авсан мэдээллээс бизнесийн болон хуульд заасан бусад нууцад хамааруулсан мэдээллийг ил болгосон;

1.3.өр төлбөртэй этгээд болон түүний төлөөлөгчөөс бусад хамааралгүй этгээдэд болон олон нийтэд өр төлбөрийн талаар мэдээлсэн;

1.4.бүртгэх байгууллагын шаардсан мэдээллийг худал мэдээлсэн;

1.5.бүртгэлээс хассан шийдвэр гарснаас хойш өр барагдуулах гэрээ шинээр байгуулсан, эсхүл гэрээгээ бусад өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгчид шилжүүлсэн бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлд бүртгэгдээгүй этгээд өр барагдуулах үйл ажиллагаа эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шүүхийн бус журмаар өр багадуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлд 7.2.12 дахь заалт нэмсүгэй:

“7.2.12.өр барагдуулах зорилгоор өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгчид гэрээний дагуу гаргаж өгсөн.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн бус журмаар өр багадуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 18 дугаар зүйлд 18.2.3 дахь заалт нэмсүгэй:

“18.2.3.өр барагдуулах зорилгоор өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгчид гэрээний дагуу гаргаж өгсөн.”

2 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2.3 дахь заалтын дугаарыг “18.2.2” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Шүүхийн бус журмаар өр багадуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтын “зээлдүүлэгч,” гэсний дараа “өр барагдуулах алба,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шүүхийн бус журмаар өр багадуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг